



МОНГОЛ УЛСЫН  
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/24


Улаанбаатар хот

Баримтлах чиглэл батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5.16, 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Цахим Үндэстэн” баримтлах чиглэлийг хавсралт ёсоор баталсугай.
2. Дээрх баримтлах чиглэлийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулахыг Бодлого, төлөвлөлтийн газрын дарга /З.Гантогоо/-д үүрэг болгосугай.
3. “Цахим Үндэстэн” баримтлах чиглэлийн хэрэгжилтийг хангуулахаар жил бүр яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд арга хэмжээ болгон тусгах, холбогдох төсвийг суулгах ажлыг Төрийн Захиргааны Удирдлагын газрын дарга /Д.Жавхлан/-д даалгасугай.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙД БӨГӨӨД ЦАХИМ ХӨГЖИЛ,  
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙДЫН  
ҮҮРЭГ ХАРИУЦАГЧ



ЦЭНХ-АМГАЛАН

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын  
20~~22~~<sup>20</sup> оны ~~11~~<sup>05</sup> дугаар сарын ~~18~~<sup>18</sup> -ны өдрийн  
~~11~~<sup>11</sup> дугаар тушаалын хавсралт



ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ

## “ЦАХИМ ҮНДЭСТЭН” БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ (2022-2027)

Улаанбаатар хот

## “ЦАХИМ ҮНДЭСТЭН” БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

### Цахим үндэстэн:

Мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан цомхон, чадварлаг төрийн бүтцийг цогцлоон бэхжүүлж, өрсөлдөх чадвартай бүтээлч иргэдийг бий болгож, дижитал эдийн засгийг хөгжүүлэн, монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ.

### Эрхэм зорилго:

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн бүх салбарт харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, мэдлэг оюунд тулгуурласан цахим үндэстнийг цогцлоон хөгжүүлнэ.

### Зорилтууд:

1. Мэдээллийн технологи, харилцаа холбооны өсөн нэмэгдэх хэрэгцээ шаардлагыг хангахуйц суурь **дэд бүтцийн** бэлэн байдлыг хангана.
2. Нийгэм, эдийн засгийн бүх салбарт харилцаа холбоо, мэдээллийн технологи, инновацыг нэвтрүүлж, бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх замаар хүнд сурталгүй, шуурхай, ил тод **цахим засаглалыг** хөгжүүлнэ.
3. Цахим орчинд үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэн, төр, хувийн хэвшил, иргэний мэдээллийн аюулгүй байдлын мэдлэг, ойлголтыг дээшлүүлж, **мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг** хангана.
4. Бүх нийтийн тоон бичиг үсгийн чадавхыг дээшлүүлэн, тоон хуваагдлыг бууруулж, харилцаа холбоо, мэдээллийн технологийн ололт амжилтад тулгуурлан нийгэм эдийн засгийн бүхий л салбарт инновац хийх чадвартай **бүтээлч иргэдтэй** болно.
5. Мэдээллийн технологи, их өгөгдөл, хиймэл оюун ухаан, юмсын интернэт, үүлэн технологи, блокчэйн зэрэг дэвшилтэт технологид суурилсан системүүдийг нэвтрүүлэх, электроникийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, **инновац, үйлдвэрлэлийг** дэмжих замаар дижитал эдийн засгийг хөгжүүлнэ.
6. Нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт харилцаа холбоо, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлж, **өрсөлдөх чадвар, бүтээмж, үр өгөөжийг** дээшлүүлнэ.

Стратегийн зорилтын шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж, суурь болон зорилтот түвшин

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин, 2027	Мэдээллийн эх сурвалж
<b>Нэг. Дижитал дэд бүтэц</b>					
1	Ази, Европыг холбосон өндөр хурдны сүлжээний мэдээллийн урсгалын хэмжээ	Г бит/сек	780 (2022 оны байдлаар)	5 дахин өснө.	Салбарын судалгаа
2	Сум, суурин газрын багтаамж	М бит/сек	155 (2022 оны байдлаар)	1024	Салбарын судалгаа
3	Өргөн зурвасын интернэтэд холбогдсон өрхийн нэвтрэлтийн түвшин	хувь	33 (2020 оны байдлаар)	70	ОУЦХБ
4	Интернэт ашигладаг хүн амын нэвтрэлтийн түвшин	хувь	90 (2020 оны байдлаар)	95	ОУЦХБ
5	Харилцаа холбооны дэд бүтцийн индекс (TII)	индексийн үзүүлэлт	0.6135 (2020 оны байдлаар)	0.71	НҮБ-ын цахим засгийн судалгаа
6	Хөдөлгөөнт холбооны 5-р үеийн технологид суурилсан сүлжээний хамрах хүрээг Монгол Улсын нийт хүн амд хүргэх түвшин	хувь	0 (2022 оны байдлаар)	70	салбарын статистик тоо баримт
7	Шуудангийн үйлчилгээний дэд бүтцийн хүчин чадал, хүртээмжийг нэмэгдүүлж, нэг хүнд ногдох шуудан хүргэлтийн тоо, хэмжээг нэмэгдүүлэх	нэг хүнд ногдох шууд, хүргэлтийн тоо	1 (2020 оны байдлаар)	2	салбарын судалгаа
<b>Хоёр. Цахим засаглал</b>					
8	Цахим засгийн хөгжлийн индекс (EGDI)	индексийн үзүүлэлт	0.6497 (2020 оны байдлаар)	0.74	НҮБ-ын цахим засгийн судалгаа 2020 он

9	Цахим үйлчилгээний индекс (OSI)	индексийн үзүүлэлт	0.5294 (2020 оны байдлаар)	0.72	НҮБ-ын цахим засгийн судалгаа
10	Цахим оролцооны индекс (EPI)	индексийн үзүүлэлт	0.6071 (2020 оны байдлаар)	0.70	НҮБ-ын цахим засгийн судалгаа 2020 он
<b>Гурав. Кибер аюулгүй байдал</b>					
11	Кибер аюулгүй байдлын санал асуулгын техник, үйл ажиллагааны индекс	индексийн үзүүлэлт	6.02 (2021 оны байдлаар)	9.2	ОУЦХБ-ын Кибер аюулгүй байдлын санал асуулга
12	Кибер аюулгүй байдлын санал асуулгын хамтын ажиллагааны индекс	индексийн үзүүлэлт	6.82 (2021 оны байдлаар)	9.76	ОУЦХБ-ын Кибер аюулгүй байдлын санал асуулга
<b>Дөрөв. Тоон бичиг үсгийн чадавх</b>					
13	Иргэдийн тоон бичиг үсгийн чадавх	Хувь	43.8 (2021 оны байдлаар)	50	ҮСХ, Өрхийн судалгаа
14	Хүмүүн капиталын индекс (HCI)	индексийн үзүүлэлт	0.8063 (2020 оны байдлаар)	0.85	НҮБ-ын цахим засгийн судалгаа
<b>Тав. Инновац, үйлдвэрлэл</b>					
16	Өндөр технологи, харилцаа холбооны бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн өсөлт	хувь	1 (2020 оны байдлаар)	3	Үндэсний хөгжлийн газар
17	Мэдээлэл харилцаа холбооны салбарын орлогын өсөлтийн хувь	хувь	12 (2020 оны байдлаар)	25	Салбарын судалгаа
18	Мэдээлэл, харилцаа холбооны салбарын хөрөнгө оруулалтын өсөлтийн хувь	хувь	12 (2020 оны байдлаар)	25	Салбарын судалгаа
<b>Зургаа. Бусад салбарын хөгжлийг МХХТ-оор дэмжих</b>					
19	Цахим арилжааны индекс	индексийн үзүүлэлт	58 (2019 оны байдлаар)	62	UNCTAD

					B2C e-Commerce Index,
20	Дижитал өрсөлдөх чадварын бэлэн байдлын индекс	индексийн үзүүлэлт	40.6 (2020 оны байдлаар)	42.4	Дижитал өрсөлдөх чадварын индекс (IMD WORLD)

## ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгал болон дэлхий нийтээрээ цахим шилжилтэд шилжиж буй өнөө үед харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшил нь хөгжлийн хурдасгуур, цахим үндэстнийг цогцлоон хөгжүүлэх гол хүчин зүйл болж байна.

**Дижитал дэд бүтэц:** Монгол Улсын харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хөгжил өнөөг хүртэлх хугацаанд хөдөө, орон нутагт мэдээлэл, харилцаа холбооны шинэлэг үйлчилгээ нэвтрүүлэх, техник технологийн суурь дэд бүтцийг өргөтгөн шилэн кабелийн сүлжээ 49,943 км, радио релейний сүлжээний тархалт 8400 км-т хүрч, манай улсын бүх аймаг, сумын төв, томоохон суурин газрууд хөдөлгөөнт холбооны сүлжээнд холбогдсон. Үүрэн утас хэрэглэгчдийн тоо 2002 онд 235 мянга байсан бол 2021 оны хагас жилийн байдлаар 4 сая 363 мянгад хүрч, 100 хүнд ногдох үүрэн утас хэрэглэгчийн тоо 136 болсон нь хөгжиж буй орнуудын болон дэлхийн дунджаас харьцангуй өндөр байна. Хөдөлгөөнт холбооны 4 дэх үеийн технологийг 2016 онд нэвтрүүлэн одоогийн байдлаар 2 сая 900 мянга гаруй хэрэглэгчтэй болсон байна. Монгол Улсад дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5G технологийг нэвтрүүлэхэд баримтлах бодлогын чиглэлийг 2020 оны 4 дүгээр сарын 21-ний А/45 тушаалаар батлан гаргасан.

**Интернэтийн бүтцийн хувьд** Монгол Улсад интернэтийн үйлчилгээ нэвтэрсэн 26 жилийн хугацаанд 70 гаруй компани интернэтийн үйлчилгээ эрхэлж, гадаад гарцын урсгалын хэмжээ 780 Г бит/сек, интернэт хэрэглэгчдийн тоо давхардсан тоогоор 5,450.61 мянга хүрснээс 94,41 хувь нь хөдөлгөөнт өргөн зурвасын үйлчилгээг хэрэглэж байна.

Монгол Улсад Өргөн нэвтрүүлгийн тухай хууль 2019 оны 12-р сард батлагдан гарснаар өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх хууль эрхзүй, зохицуулалтын орчин бүрдэж, төрөөс **өргөн нэвтрүүлгийн хөгжлийг** дэмжих, радио, телевизийн хөтөлбөрт үндэсний бүтээл, үндэсний түүх, соёл, уламжлал, хүүхэд, танин мэдэхүйн нэвтрүүлэг бэлтгэн хүргэх үүрэг хүлээлгэх, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг ард иргэдэд хүртээмжтэй хүргэхэд эрхзүйн орчин сайжирсан юм. Өнөөдрийн байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт 260 өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгогдсоноос Монголын Үндэсний олон нийтийн телевизийн 5, олон нийтийн радиогийн 4, Улаанбаатар хотод өргөн нэвтрүүлгийн телевизийн 18, арилжааны телевизийн 62, төлбөртэй телевизийн 11, радиогийн 33, орон нутагт телевизийн 64, радиогийн 26, мөн радио, телевизийн газрын сүлжээний 2, олон суваг дамжуулах 35 үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл тус тус байна. Монгол Улсын нийт өрхийн 97.3 хувь нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг радио, телевизийн газрын сүлжээ болон

олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр дамжуулан хүлээн авч үзэж байна. Түүнчлэн олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр гадаадын дахин дамжуулж байгаа 199 сувгийг хэрэглэгч хүлээн авч байна.

Телевизийн өргөн нэвтрүүлгийг 2015 оны 10 дугаар сарын 15-ны өдөр тоон технологид бүрэн шилжүүлсэн. Улс орон даяар урт, дунд, богино долгионы их чадлын 10 станцаар үндэсний олон нийтийн радиогийн 1, 2 дугаар хөтөлбөрийг дамжуулж байгаа бөгөөд нийт нутаг дэвсгэрийн 50 гаруй хувь нь дунд сонсголын, хүн амын 40 гаруй хувь нь найдвартай сонсголын бүсэд хамрагдаж байна. Радио, телевизийн газрын сүлжээ, дэд бүтцийг өргөтгөх, сүлжээний багтаамжийг нэмэгдүүлэх, радиогийн дамжуулах сүлжээг тоон технологид шилжүүлэх, дэд бүтцийн бэлэн байдлыг хангах, өргөн нэвтрүүлгийн салбарт үндэсний ашиг сонирхол, үндэсний дархлааг хамгаалах, эзэмшлийн ил тод байдлыг хангах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлж, салбарын хөгжлийг дэмжин хөгжүүлэхэд онцгой анхаарч төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох зайлшгүй шаардлагатай байна.

**Шуудангийн дэд бүтцийн хувьд** Монгол Улсын шуудангийн салбарын хууль эрх зүй, зохицуулалтын таатай орчин бүрдэж, зах зээлийн өрсөлдөөн нэвтэрсэн ба шуудангийн үйлчилгээний хүртээмжийн чанар жилээс жилд сайжирч байгаа боловч бүсчлэлээс хамааран харилцан адилгүй, эрс ялгаатай байна. Аймаг, орон нутаг, алслагдсан сум сууринд оршин сууж буй иргэдийн шуудангийн үйлчилгээний хүртээмж, шуудангийн үйлчилгээний хурд хангалтгүй байна.

Улсын хэмжээнд 2021 оны байдлаар 95 аж ахуйн нэгж, байгууллага шуудангийн ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа хэдий ч, шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигчээс бусад тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгж, байгууллагууд орон нутагт шуудангийн үйл ажиллагаа явуулахгүй байна. Улмаар зөвхөн хүн ам нягт суурьшсан Улаанбаатар хотын жижиг зах зээлд хэт олон өрсөлдөгч үйл ажиллагаа явуулж байгаа боловч, зөвхөн шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигч алслагдсан бүс нутагт, хамгийн зардал өндөртэй хэсэгт нь ажиллаж, алдагдал хүлээж байгаа нь үндсэн сүлжээ эзэмшигчийн найдвартай, тогтвортой ажиллах орчин нөхцөлийг эрсдэлд оруулж байна.

Харин улс хоорондын шууданг дэлхийн 192 улстай агаараар шуудан солилцдог. Дэлхийн шуудан холбооноос жил бүр гаргадаг шуудангийн хөгжлийн индексээр Монгол Улс 2020 онд 115 дугаар байр, 2021 онд 57 дугаар байрыг эзэлсэн.

**Сансрын холбоо**, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээнд өнөөгийн байдлаар 6 аж ахуйн нэгж, байгууллага хиймэл дагуулын нийт 444 МГц давтамжийн зурвас ашиглан хэрэглэгчдэд интернет, үүрэн холбоо, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ хүргэхээс гадна радио навигацийн холбоонд ашиглаж байна. Үндэсний хиймэл дагуул хөөргөх чиглэлээр “Сансрын холбооны болон тандан судалгааны хиймэл дагуул хөөргөх техник, эдийн засгийн үндэслэл, техникийн урьдчилсан дизайн боловсруулах” ТЭЗҮ-ийг 2012 онд боловсруулж, энэхүү ТЭЗҮ-д тулгуурлан 2012 онд Засгийн газрын 137 дугаар тогтоолоор “Монгол Улсын Үндэсний хиймэл дагуул” хөтөлбөрийг баталснаар сансар судлал, сансрын технологийг Монгол Улсад хөгжүүлэн нутагшуулах, үндэсний хиймэл дагуул хөөргөх, эзэмших, ашиглах боломж бүрдсэн. Үндэсний хиймэл дагуул хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой 2013 оноос “Сансрын үндэсний зөвлөл”-ийг Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар байгуулан ажиллаж байна. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/16 дугаар тушаалаар “Монгол Улсад нам орбитын хиймэл дагуулын сүлжээ

ашиглахад баримтлах чиглэл"-ийг баталсан нь нам орбитын хиймэл дагуулын сүлжээг онцгой байдал, бүх нийтийн үүрэгт үйлчилгээний зорилгоор дамжуулах сүлжээнд ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн. Цаашид сансар судлал, сансрын технологитой холбоотой хууль, эрхзүйн орчиныг бүрдүүлэх, "Төрөөс сансар судлалын талаар баримтлах бодлого", баримт бичгийг батлуулах шаардлага тулгарч байна.

**Цахим засаглал:** Монгол Улсын Засгийн газраас цахим засаглалыг хөгжүүлэх бодлого баталж, холбогдох төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж ирсэн боловч төрийн удирдлагын манлайлал, төрийн байгууллагуудын уялдаа холбоо, үүрэг, оролцоо хангалтгүй, нэгдсэн зохицуулалтгүй, үр ашиг багатай, хөрөнгө оруулалтын давхардал зэргээс шалтгаалж цахим шилжилтийн явц удааширч, 2 жил тутам гардаг Олон Улсын цахим хөгжлийн индексээр 2016 онд 84, 2020 онд 92 дугаарт орсон байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Цахим гарын үсгийн тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиуд 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан нь дээрх асуудлуудыг шийдвэрлэж, цахим засаглалын хөгжлийг хурдасгах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэв. Одоогоор эдгээр хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор даган гарах журам, аргачлал, стандартыг боловсруулан, дагаж мөрдөх хэрэгжилтийг ханган ажиллах шаардлагатай байна.

**Кибер аюулгүй байдал:** Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-д мэдээллийн аюулгүй байдлыг үндэсний аюулгүй байдлын нэг бүрэлдэхүүн хэмээн зарлаж, тодорхой зорилтуудыг дэвшүүлсэн.

Олон Улсын Цахилгаан холбооны байгууллагаас 2 жил тутам гаргадаг "Кибер аюулгүй байдлын индекс"-ээр Монгол Улс 2020 онд 193 орноос 120 дугаар байрыг эзэлсэн байна. УИХ-аас "Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай", "Кибер аюулгүй байдлын тухай хууль"-ийг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталсан нь Монгол Улсад кибер аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэх үндсэн нөхцөл болж байна. Энэхүү хуулийн хэрэгжилтийг ханган ажиллахад дагаж мөрдөх журам, аргачлал, шаардлагыг боловсруулан батлуулах, хүний нөөцийг чадавхжуулах, иргэд олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, кибер халдлага, зөрчилтэй тэмцэх төв байгуулах болон гадаад, дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

**Тоон бичиг үсгийн чадавх:** Дэлхий нийтэд цахим шилжилтийн давлагаа явагдаж байгаа өнөө үед компьютер, хөдөлгөөнт төхөөрөмж болон бусад тоног төхөөрөмжтэй харьцах, хэрэгцээт мэдээллийг эрж хайх, олж авах чадвартай хүн энгийн чадвартай хүнд тооцогдож байна. Монгол Улсад 2018 оны Мэдээлэл, харилцаа холбооны технологи ашиглах чадварыг үнэлэх түүвэр судалгаагаар бүх нийтийн цахим-ур чадварын үзүүлэлт 31% гэж тодорхойлогджээ.

Харин Үндэсний Статистикийн хороо, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын 2021 онд хамтран хэрэгжүүлсэн "Өрхийн болон хувь хүний мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хэрэглээ" судалгаанд оролцогчдын сүүлийн 3 сард ашигласан мэдээллийн технологийн хэрэглээнд тулгуурлан үр дүнг гаргасан. Нийт судалгаанд оролцогчдын **43.8% нь мэдээллийн ур чадвартай** буюу мэдээлэл хайж олох, үйлчилгээний байгууллагуудын веб хуудаснаас мэдээлэл авах, дижитал орчин дах өгөгдөл, мэдээлэл, агуулгыг хуулбарлах, шилжүүлэх хэрэгсэл ашиглах, интернэтийн орчинд файл хадгалах, **38.8% нь харилцаа холбооны ур чадвартай** буюу интернэтээр утсаар ярих, видео дуудлага хийх, олон нийтийн сүлжээнд оролцох, хавсаргасан файлуудтай мессеж

илгээх, өөрөө бүтээсэн контентоо бусадтай хуваалцах, веб хуудсанд байршуулах, **27% нь асуудал шийдвэрлэх ур чадвартай** буюу интернэт банк хэрэглэх, программ хайх, татаж авах, суулгах, тохируулах, цахим худалдаа хийх, төхөөрөмжүүд хооронд файл эсвэл программ дамжуулах, **9.8% нь программ хангамжийн ур чадвартай** буюу текст боловсруулдаг программ хангамж ашиглах, мэдээллийг цэгцлэх, дүн шинжилгээ хийхэд хүснэгтийн ахисан түвшний функцийг ашиглах, зураг, видео эсвэл аудио файлуудыг засварлахад программ хангамж ашиглах, илтгэлийн программ хангамж бүхий электрон үзүүлэнг бүтээх, программчлалын хэл дээр код бичих, **6.4% нь аюулгүй байдлын ур чадвартай** буюу онлайнаар олж авсан мэдээллийн найдвартай байдлыг шалгах, төхөөрөмж, онлайн дансыг хамгаалахын тулд аюулгүй байдлын үр дүнтэй арга хэмжээг тохируулах зэрэг чадваруудыг эзэмшсэн байна.

Энэхүү үзүүлэлт нь энэ талбарт хийх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, иргэдийн мэдээллийн технологийн суурь мэдлэгийг дээшлүүлэх, иргэдэд цахим-ур чадвар, боловсролыг эзэмшүүлэх замаар шилжилтийн үеийг даван туулахад нь онцгой анхаарч, төрөөс дэмжлэг үзүүлэх шаардлагатайг харуулж байна.

**Инновац, үйлдвэрлэл:** Дэлхийн инновацын индексийн 2020 оны үзүүлэлтээр Монгол Улс 131 орноос 58 дугаар байранд эрэмбэлэгдсэн нь төдийлөн муу үзүүлэлт биш боловч тус индексийг гаргаж буй шалгуур үзүүлэлтүүдээс байгууллага /улс төр, хууль эрх зүй, эдийн засаг/-ын орчин, хүний нөөцийн хөгжил, судалгаа шинжилгээ, дэд бүтэц, технологийг бий болгох мэдлэг, бизнесийн төлөвшил зэрэг үзүүлэлтээр доогуур үнэлгээ авсан байна. Харин зах зээл болон бүтээлч үйлдвэрлэлийн хувьд 13, 30 дугаар байранд жагссанаас харахад Монгол Улсын зах зээлийн нөхцөл байдал, бүтээлч үйлдвэрлэлийн түвшин харьцангуй дээгүүр буюу цаашид илүү өргөн хүрээг хамарч, шинэ шатанд гарах боломж байгааг илтгэж байна. Иймд инновацыг хөгжүүлэхэд нэн чухал шаардлагатай хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, дэд бүтцийг бий болгох, судалгаа, шинжилгээний үйл явцыг чанаржуулах, хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэхэд анхаарах шаардлагатай байна. Түүнчлэн инновац, дэвшилтэт технологийн кластер, мэдээллийн технологийн аж үйлдвэрийн парк байгуулах, үндэсний тоон контент үйлдвэрлэлийг хөгжүүлэх, их өгөгдөл, хиймэл оюун ухаан, юмсын интернэт, үүлэн технологи, блокчэйн зэрэг дэвшилтэт технологиудыг хэрэглээнд нэвтрүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт бизнесийн таатай орчныг бүрдүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

**Үндэсний хөгжлийн хурдасгуур:** “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичигт Олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацын тогтолцоог хөгжүүлж, эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн нэг болгох зорилт тавьсан. Аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгалын өнөө үед Монгол Улс мэдээллийн технологи, программ хангамж, үндэсний тоон контент болон газрын ховор элемент ашиглан электроникийн үйлдвэрлэл хөгжүүлж, экспортод гарган эдийн засгийн шинэ секторыг бий болгох шаардлагатай байна. Түүнчлэн уул уурхай, хөдөө аж ахуй давамгайлсан уламжлалт эдийн засгийн бүтцийг өндөр технологи, мэдлэг, инновацад суурилсан дижитал эдийн засгийн бүтцэд шилжүүлэхэд салбар хоорондын хөгжлийг дэмжин ажиллах нь хөгжлийг хурдасгагч хөшүүрэг болж байна.

## ЗОРИЛТУУД

### Нэг. ДЭД БҮТЦИЙН БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ

Мэдээллийн технологи, харилцаа холбооны өсөн нэмэгдэх хэрэгцээ шаардлагыг хангахуйц суурь дэд бүтцийн бэлэн байдлыг хангана.

#### 1.1 Өндөр хурдны өргөн зурвасын сүлжээг өргөтгөн хөгжүүлнэ.

- 1.1.1 Монгол Улсын хүн ам, нутаг дэвсгэрийг бүрэн хамарсан, сүлжээний найдвартай, чанартай, хүртээмжтэй, дэвшилтэт технологийн үйлчилгээг нэвтрүүлэх мэдээлэл, харилцаа холбооны үндсэн сүлжээг өргөтгөн хөгжүүлнэ.
- 1.1.2 Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх, газар зүйн байршлын хувьд ялгаатай хоёроос дээш олон улсын интернэт транзит урсгал дамжуулах өндөр багтаамжтай сүлжээ байгуулна.
- 1.1.3 Хүн ам суурьшсан төв суурин газар, аялал, жуулчлалын бүс нутаг, А зэрэглэлийн зам дагуу болон боомтуудад харилцаа холбооны дэд бүтцийг байгуулна.
- 1.1.4 Аж үйлдвэрийн 4 хувьсгалын хурдасгуур болсон хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн технологийг нийгэм эдийн засгийн бүх салбарт нэвтрүүлэхэд салбар хоорондын хамтын ажиллагааг идэвхжүүлж дэмжинэ.
- 1.1.5 Интернэтийн дижитал дэд бүтцийн хөгжлийн тогтвортой байдлыг дэмжиж интернэтийн чанар болон нээлттэй байдлыг сайжруулна.
- 1.1.6 Гамшгийн болон онцгой байдлыг үеийн холбооны сүлжээ зохион байгуулах төлөвлөгөөг тодорхойлж, шаардлагатай өргөтгөл хийж, бэлэн байдлыг хангана.
- 1.1.7 Зам, тээвэр, эрчим хүч, соёлын дэд бүтцийн болон барилга, хот байгуулалтын төлөвлөлт, бүтээн байгуулалттай уялдуулан мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, түүний дэд бүтцийг төлөвлөж байгуулна.

#### 1.2. Өргөн нэвтрүүлгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

- 1.2.1. Өргөн нэвтрүүлгийн орчинд үндэсний дархлааг хамгаалах, үндэсний түүх, соёл уламжлал, боловсрол, шинжлэх ухаан, хүүхэд танин мэдэхүйн нэвтрүүлгийн бүтээл үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх, үндэсний бүтээлийн хувь хэмжээг нэмэгдүүлнэ.
- 1.2.2. Өргөн нэвтрүүлгийн эзэмшлийн ил тод байдлыг хангах, өргөн нэвтрүүлгийн эзэмшил, хэт төвлөрлөөс сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 1.2.3. Интернэтэд суурилсан телевиз, радио, номын сан, соёлын байгууллагын хүртээмжийг нэмэгдүүлж, хэрэглэгчдэд хүссэн контентоо үзэх, номоо унших, үзвэр үйлчилгээг авах боломжийг бий болгоно.
- 1.2.4. Өргөн нэвтрүүлгийн салбарын хүний нөөцийг чадавхжуулна.
- 1.2.5. Аймаг, орон нутгийн радио, телевизийн хөтөлбөрийг сум, суурин газарт хүргэх сүлжээ, дэд бүтцийг өргөтгөж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.2.6. Төрийн өмчийн радиогийн газрын сүлжээг тоон технологид шилжүүлэх, радио, телевизийн газрын сүлжээ, дэд бүтцийг өргөтгөх, сүлжээний багтаамжийг нэмэгдүүлэх, хүн амыг мэдээлэл хүлээн авах, чанартай үйлчилгээгээр хангах, гамшгийн үеийн зарлан мэдээлэх үйл ажиллагааг дэмжинэ.